

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН
ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

*Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан
заавар, аргачлалын дагуу зардлыг хуваарилж, зарцуулсан байна.*

Аудитын код: ДГА-2025/63-ШТА-НА

	Дарга, тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Цахим хуудас:	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
www.audit.mn	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Дорноговь аймаг	Аудитор:	Н.Мөнхнасан
2025 оны 07 сар		Цахим хаяг: Munkhnasann@audit.gov.mn
		А.Дамчой
		Цахим хаяг: damchoia@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл:	7
1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН, ЗАРЦУУЛСАН БАЙНА	8
1.1 Улсын төсвөөс олгох сонгууль зохион байгуулахтай холбогдох зардлыг журмын дагуу хуваарилсан байна.	8
1.1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 74.4 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна	8
1.1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд 40.4 сая төгрөгийн зардлыг хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажилласан байна.	9
1.1.3 Аймгийн улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын төсөвлөлтийг дээд байгууллагаас төсөвлөн, хуваарилсан байна.	10
1.2 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж СЕХ-ны дансанд 0.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	10
1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажилласан байна.....	10
1.2.2 Зардлын гүйцэтгэлийг СЕХ-оос баталсан журмын дагуу тайлагнасан байна.	12
1.2.3 Аймгийн сонгуулийн хороо төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажилласан байна	13
АУДИТЫН ДҮГНЭЛТ	14

Товчилсон үгийн жагсаалт

АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудит
ДГА	Дорноговь аймаг
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ССХ	Сумын сонгуулийн хороо
ТАБ	Төрийн аудит байгууллага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ШТА	Шууд тайлагналын аудит

Хүснэгтийн товъёог:

Хүснэгт 1. СЕХ-оос АСХ-д хуваарилсан төсөв, эдийн засгийн ангиллаар	9
Хүснэгт 2. Сонгуулийн зардлын санхүүжилт	9
Хүснэгт 3. Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн хуваарилалт	10
Хүснэгт 4. Аймаг, сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл	11
Хүснэгт 5. Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн гүйцэтгэл	11
Хүснэгт 6. Сонгуулийн Ерөнхий хорооноос олгосон төсвийн гүйцэтгэл	11
Хүснэгт 7. Зардал хооронд шилжүүлэн зарцуулсан зардлын гүйцэтгэл.....	12

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.”, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилго, зорилт</p>	<p>Орон нутгийн 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлангийн төлөвлөлт, зарцуулалтад дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн сонгуулийн хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.</p> <p>Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>Орон нутгийн сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөн, хуваарилж, зарцуулсан эсэх.</p> <p>Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх.</p>
<p>Аудитын хамрах хүрээ</p>	<p>Аудитыг орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-оос аймгийн сонгуулийн хороонд, УБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалуудыг хамруулан авч үзлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан шалгагдагчийн сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>

	<p>Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:</p> <ul style="list-style-type: none"> -Төрийн аудитын тухай хууль; -Төсвийн тухай хууль; -Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; -Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль; -СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам" -Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.
<p>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, аудитор Н.Мөнхнасан, А.Дамчой нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс хугацаанд нь хэрэгжүүлж, аудитын тайланг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр холбогдох байгууллагад хүргүүлээ.</p>

Ерөнхий мэдээлэл:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, тухайн оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн 04/11 дүгээр тогтоолоор сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах сонгуулийн хорооны даргаар аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ц.Батсугир, Нарийн бичгийн даргаар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Цэндмаа, гишүүдээр Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Батзориг, Татварын хэлтсийн дарга Г.Хосбаяр, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Содхүү, Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний Улсын бүртгэгч Э.Ариунтуяа, Сайншанд сумын 5 дугаар сургуулийн математикийн багш Б.Оргилбаяр нарын 7 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны Нягтлан бодогчоор аймгийн ИТХ-ын Нягтлан бодогч Б.Наранцацралыг аймгийн Сонгуулийн хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр захирамжаар, сумдын сонгуулийн хэсгийн хорооны Мэдээлэл технологийн даамлаар ажиллах 6 албан хаагчийг Сонгуулийн хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар захирамжаар тус тус томилсон байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/177 дугаар албан бичгээр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулах чиглэл, 05 дугаар сарын 23-ны өдрийн 3/230 дугаар албан бичгээр санхүүжилтийн хуваарь, хавсралтаар төсвийн зарцуулалтын тайлбарыг тус тус ирүүлсэн байна. Санхүүжилтийг 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгийн 2 дугаар хавсралтаар АСХ-нд нийт 74.4 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус хуваарилсан байна.

Дорноговь аймгийн сонгуулийн хороо болон 3 сумын сонгуулийн хороо, 3 хэсгийн хороо мөн сонгуулийг автоматжуулсан системээр зохион байгуулдагтай холбоотойгоор аймгийн Сонгуулийн хорооны дэргэдэх МТБ-т 3, үндсэн болон нөөц даамлаар 6, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар 3, аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын хэлтсээс хамгаалалт, хяналт, хэв журам, хэрэг мөрдөн шалгах зэрэг чиглэлээр 3 албан хаагч томилогдон, нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулах зардалд УБЕГ-аас аймгийн УБХ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар 4.6 сая төгрөг хуваарилсан байна. Улсын төсвөөс олгосон зардлын зарцуулалтын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгав.

Аймгийн Сонгуулийн хороонд нийт 74.4 сая төгрөгийг СЕХ-оос хуваарилсныг аймгийн Төрийн сан дахь 100060022001 тоот дансаар дамжуулан гүйцэтгэлээр 74.1 сая төгрөг зарцуулж, 0.3 сая төгрөгийг хэмнэж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН, ЗАРЦУУЛСАН БАЙНА.

1.1 Улсын төсвөөс олгох сонгууль зохион байгуулахтай холбогдох зардлыг журмын дагуу хуваарилсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т "Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ", 10.2-т "Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ", 10.3-т "Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж тус тус заасан.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 3/230, 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралтаар АСХ-нд нийт 74.4 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус хуваарилсан байна.

1.1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 74.4 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна" гэж заасан байна.

Дорноговь аймгийн харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд аймгийн сонгуулийн хороонд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04/11 дүгээр тогтоолоор батлагдсан 7 хүн, 3 сумын сонгуулийн хороонд 15 хүн, 3 сонгуулийн хэсгийн хороонд 23 хүн, нийт 45 хүн ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу үйлдэгдсэн, Дорноговь аймгийн хэмжээнд сонгуулийн хэсгийн хороодод хүргэсэн эхний нэрийн жагсаалтад нийт 1953 сонгогч бүртгэгдсэн байсан. Үүнээс хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, "түр хасав" төлөвийг хасах, лавлагаа мэдээллийг оруулан эцсийн байдлаар гаргасан нэрийн жагсаалтад 1953 сонгогч бүртгэгдсэн байна.

СЕХ нь Дорноговь аймгийн нөхөн сонгууль зохион байгуулах 3 сумын нийт сонгогчид болон санал авах байр тэдгээрт ажиллах гишүүдийн тоог үндэслэн сонгуулийн зардлыг төлөвлөн УИХ-аар батлуулж, аймгийн Сонгуулийн хороонд 74.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

Хүснэгт 1. СЕХ-оос АСХ-д хуваарилсан төсөв, эдийн засгийн ангиллаар

№	Зардлын нэр	Төсөв		Нийт төсөв
		АСХ	ССХ	
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	0.2	-	0.2
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	1.4	-	1.4
3	Бичиг хэргийн зардал	0.3	0.9	1.2
4	Шуудан, холбооны зардал	0.4	1.2	1.6
5	Унааны зардал	1.2	2.9	4.1
6	Санал авах байр бэлтгэх зардал	-	0.9	0.9
7	Сурталчилгааны зардал	-	2.1	2.1
8	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	0.8	-	0.8
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	8.2	-	8.2
10	Томилолтын зардал	3.9	-	3.9
11	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	-	0.4	0.4
12	Шуурхай багийн зардал	2.3	0.3	2.6
13	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, НДШ, хоолны зардал	7.8	31.7	39.6
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ, хоолны зардал	7.5	-	7.5
	Нийт дүн	34.0	40.4	74.4

СЕХ-оос АСХ-нд хуваарилсан зардлын дийлэнх хэсгийг буюу 50 хувийг сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал эзэлж байгаа бол хамгийн бага хувийг хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал 0.2 сая төгрөг буюу 0.1 хувийг эзэлж байна.

1.1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд 40.4 сая төгрөгийн зардлыг хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь СЕХ-оос өгсөн тайлбар аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд зардлын төсвийг хуваарилна" гэж заасан байна.

СЕХ-оос аймагт 11 нэр төрлийн зардалд хуваарилсан 34.0 сая төгрөгийг зарцуулах зардлын ангилал болон ССХ-нд хуваарилах зөвлөмж, аргачлалыг 2 удаа ирүүлсэн. Уг зөвлөмж, аргачлалын дагуу АСХ-оос 3 ССХ-нд 40.4 сая төгрөгийн зардлыг хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажилласан байна.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын санхүүжилт

Байгууллагын нэр	(сая төгрөгөөр)			
	04/29	05/23	06/12	Нийт
Аймгийн Сонгуулийн хороо	3.5	8.9	21.6	34.0
Сумдын Сонгуулийн хороо	4.9	3.5	32.0	40.4
Нийт дүн	8.4	12.4	53.6	74.4

Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн хороодын санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тооны судалгааг үндэслэн сум тус бүрд бичиг хэргийн зардалд 0.3 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0.4 сая төгрөг, санал авах байр бэлтгэхэд 0.3 сая төгрөг, унааны зардлыг АСХ-д 500км*800 төгрөг, ССХ-д 400км*800 төгрөг, хэсгийн хороонд 800км*800 төгрөг-өөр тооцож хуваарилсан байна.

Хуваарилсан санхүүжилтийн 45.6 хувийг аймгийн сонгуулийн хороо, 54.3 хувийг сумын сонгуулийн хороонд зарцуулагдсан байна.

1.1.3 Аймгийн улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын төсөвлөлтийг дээд байгууллагаас төсөвлөн, хуваарилсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан.

УБЕГ-ын даргын 2025 оны А/82 дугаар тушаалаар Дорноговь аймгийн УБХ-т 5 нэр төрлийн 4.6 сая төгрөгийн зардлын санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

Хүснэгт 3. Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн хуваарилалт

№	Зардлын нэр	(сая төгрөгөөр)
		Батлагдсан төсөв
1	Итгэмжлэгдсэн ажилтны шуурхай багийн мөнгөн урамшуулал, НДШ	2.8
2	Бичиг хэргийн зардал	0.1
3	Итгэмжлэгдсэн ажилтны сургалтад ирсэн болон нэрсийн жагсаалт хүргэсэн, тоног төхөөрөмж хүлээн авсан томилолт	1.2
4	Тээвэр, шатахууны зардал	0.4
5	Шуурхай багийн зардал	0.1
	Нийт дүн	4.6

1.2 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж СЕХ-ны дансанд 0.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажилласан байна.

СЕХ-ны даргын А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, төсөв гаргах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасны дагуу аймаг, сумдын сонгуулийн хороод мөнгөн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг хөтөлж, ажил гүйлгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэлийг авч үзэхэд Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумдын сонгуулийн хороо хуваарилагдсан зардлыг 100 хувийн гүйцэтгэлтэй, аймгийн сонгуулийн хороо 98.9 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан байна.

СЕХ-оос Дорноговь аймгийн сонгуулийн хороонд 74.4 сая төгрөг хуваарилсныг гүйцэтгэлээр 74.1 сая төгрөгийн зарцуулж, үлдэгдэл 0.3 сая төгрөгийг СЕХ-ны 100900022001 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 4. Аймаг, сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	0.2	0.2	-
2	Сургалтын зардал	1.4	1.4	-
3	Бичиг хэрэг	1.2	1.2	-
4	Шуудан холбооны зардал	1.6	1.6	-
5	Унааны зардал	4.0	4.0	-
6	Санал авах байр бэлтгэх зардал	0.9	0.9	-
7	Сурталчилгааны зардал	2.1	2.1	-
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	8.2	7.9	0.3
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	0.8	0.8	-
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	0.4	0.5	-0.1
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	39.5	39.5	-
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	7.6	7.6	-
13	Томилолтын зардал	3.9	3.9	-
14	Шуурхай багийн зардал	2.6	2.5	0.1
	Нийт дүн	74.4	74.1	0.3

Дорноговь аймагт Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс /УБЕГ/ аймгийн УБХ-т 4.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосныг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Хүснэгт 5. Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Итгэмжлэгдсэн ажилтны шуурхай багийн мөнгөн урамшуулал, НДШ	2.8	2.8	-
2	Бичиг хэргийн зардал	0.1	0.1	-
3	Итгэмжлэгдсэн ажилтны сургалтад ирсэн болон нэрсийн жагсаалт хүргэсэн, тоног төхөөрөмж хүлээн авсан томилолт	1.2	1.2	-
4	Тээвэр, шатахууны зардал	0.4	0.4	-
5	Шуурхай багийн зардал	0.1	0.1	-
	Нийт дүн	4.6	4.6	-

СЕХ-оос хуваарилсан 3 удаагийн санхүүжилтийг зарцуулахтай холбоотой ирүүлсэн заавар чиглэлийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороо зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 6. Сонгуулийн Ерөнхий хорооноос олгосон төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

№	Зардлын нэр	2025.04.29 1/177	2025.05.23 3/230	2025.06.12 3/237	Нийт
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	0.2	-	-	0.2
2	Сургалтын зардал	1.4	-	-	1.4
3	Бичиг хэрэг	1.2	-	-	1.2
4	Шуудан холбооны зардал	1.6	-	-	1.6
5	Унааны зардал	4.0	-	-	4.0
6	Санал авах байр бэлтгэх зардал		0.9	-	0.9

7	Сурталчилгааны зардал	2.1	-	2.1
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	8.2	-	8.2
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	0.7	-	0.7
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	0.4	-	0.4
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал		39.6	39.6
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал		7.6	7.6
13	Томилолтын зардал		3.9	3.9
14	Шуурхай багийн зардал		2.6	2.6
	Нийт	8.4	12.3	53.7
				74.4

Сонгуулийн ерөнхий хороо дээрх журамд заасны дагуу аймгийн сонгуулийн хороонд төсвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх гэсэн чиглэлийг өгч ажилласан байна.

Айраг, Дэлгэрэх сумдын сонгуулийн хороо сурталчилгааны зардалд төлөвлөсөн 1.4 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.2.2 Зардлын гүйцэтгэлийг СЕХ-оос баталсан журмын дагуу тайлагнасан байна.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.8 "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасан.

СЕХ-оос зардлыг эдийн засгийн ангиллын дагуу хэмнэлттэй байхаар зарцуулах чиглэлийг тухай бүр өгсөн ба АСХ тус зөвлөмж аргачлалыг баримтлан хэрэгжүүлэн ажиллажээ.

Хуваарилсан зардлыг журамд заасны дагуу АСХ-с төсвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх гэсэн чиглэл өгсөн хэдий ч зарим сумдын сонгуулийн хороо нь 1.1 сая төгрөгийн зардлыг шилжүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 7. Зардал хооронд шилжүүлэн зарцуулсан зардлын гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

№	Сумын нэрс	Хэмнэгдсэн зардлыг зардал хооронд гүйлгэн зарцуулсан			
		Сурталчилгааны зардал	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	Шатахуун	Шуурхай багийн зардал
1	Айраг	0.8	0.1	(0.9)	
2	Дэлгэрэх		(0.2)		0.1

Айраг сум сурталчилгааны зардал, эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардлыг хэмнэсэн дүнгээр шатахууны зардалд, Дэлгэрэх сум шуурхай багийн хэмнэсэн зардлыг, эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардалд тус тус шилжүүлэн зарцуулсан байна.

1.2.3 Аймгийн сонгуулийн хороо төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10-т "Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих бүрэн эрхтэй" гэж заасан.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.10-т "... аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зарцуулалтад хяналт тавина", мөн журмын 4.6-д "...аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумын сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авна..." гэж заажээ.

АСХ нь сумын сонгуулийн хороодод хөрөнгийн зарцуулалтыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн анхан шатны баримтыг НББ-ийн тухай хуулийн дагуу бүрдүүлэн ажиллах зэрэг заавар зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан байна.

Сумдын сонгуулийн хорооны анхан шатны баримтыг тулган шалгаж аудит хийх явцад жолооч нарын замын хуудас, шаардах хуудас, явсан газрын маршрут, тойролтоор нийт явах замын км, шаардлагатай шатахууны тооцоолол гэх анхан шатны баримт бүрдэл бүрэн, эмх цэгцтэй ойлгомжтой шаардлага хангасан байна.

Энэ нь ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу АСХ сумдын сонгуулийн хороог арга зүйгээр ханган хяналтыг хэрэгжүүлж, ажилласан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Сонгуулийн ерөнхий хороо Дорноговь аймгийн сонгуулийн хороонд 14 нэр төрлийн зардалд нийт 74.4 сая төгрөгийн санхүүжилтийг 3 үе шатаар хуваарилан олгосон ба тухай бүрд зардлын зүйл ангилал болон хөрөнгийг зарцуулах талаар холбогдох зөвлөмж, аргачлалыг ирүүлсэн байна.

Улсын Бүртгэлийн Ерөнхий газраас нөхөн сонгууль зохион байгуулах 5-н нэр төрлийн зардалд 4.6 сая төгрөгийг аймгийн УБХ-т хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороонд 40.4 сая төгрөгийг сонгуулийн ерөнхий хорооны заавар, аргачлалын дагуу хуваарилсан байна.

Сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн зардлыг хуваарилахдаа бараа үйлчилгээний бусад зардал гэсэн эдийн засгийн нэг ангиллаар тусгадгаас сурталчилгааны зардал, эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардлаас хэмнэгдсэн 1.1 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

Сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын тайлангийн анхан шатны баримт бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнан өмнөх аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн холбогдох хууль, журмыг мөрдөн ажилласан байна.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Т.ГАН-ӨЛЗИЙ

У.ОЮУНТҮЛХҮҮР



АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

АУДИТОР:

Наса

Н.МӨНХНАСАН

АУДИТОР:

А.Дамчой

А.ДАМЧОЙ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/33

Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дугаар зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Б.Баттуяа), аймгийн Сонгуулийн хорооны дарга (Ц.Батсугир), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (С.Энх-Эрдэнэ) нарт тус тус хүргүүлсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

442501019



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.07.09 № 1-6/546

танай _____-ын № _____-т

**АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА Ц.БАТСУГИР ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалын дагуу “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах” сэдэвт нийцлийн аудитыг хийж дуусган, аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 15 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Т.ГАН ӨЛЗИЙ

442503355